



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2018.07.05 № 5/1452  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АЙМАГ /НИЙСЛЭЛ/ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС  
/ГАЗАР/-ИЙН ДАРГА НАРТ**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 29 -ний өдрийн А/120 тоот тушаалыг хүргүүлж байна. Тушаал хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана уу.

1. Архивын лавлагааны хураамж буюу иргэдэд үйлчилсэн орлогыг сар бүр хугацаанд нь төвлөрүүлж, дансны үлдэгдэлгүй байх,
2. Улирал бүрд тооцоо нийлсэн акт үйлдэх,
3. Лавлагааны үнийг тогтоосон үнээс нэмэгдүүлэн авахгүй байх.

Хавсралт 2-хуудастай.

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА

Б.ДАВААХҮҮ

My doc.SBG.SU.A-5 /18.07 r sar

1002816



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот


### Архивын лавлагааны хураамж батлах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Засгийн газрын 2014 оны "Дүрэм, журам батлах тухай" 354 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 3 дахь хэсгийн 3.1.2, "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны "Журам шинэчлэн батлах тухай" 27 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2011 оны 32 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын салбарын архивын заавар"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын байгууллагаас олгож байгаа архивын лавлагааны хураамжийг хавсралтанд дурдсанаар тогтоож, 2018 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Архивын лавлагааны хураамжийг тотоосноос нэмэгдүүлж авахгүй, үйл ажиллагааны зардалд шилжүүлэн зарцуулахгүй байх, орлогыг сар бүрийн 30-ны дотор Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох харилцах дансанд төвлөрүүлэхийг Тамгын газар, аймаг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэлийн газар /Б.Даваахүү/, Тамгын газар /Н.Эрдэнэжав/-т тус тус даалгасугай.

ДАРГА  Д.ЗОРИГТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын  
даргын 2018 оны 06 дугаар сарын  
29-ны өдрийн А/120 тоот тушаалын  
хавсралт

№	Архивын лавлагааны төрөл	Хэмжээ, төгрөгөөр
1	Ажил олгогч, байгууллага тэтгэврийн санд 1991-1994 онд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн/ төлөөгүй/ тухай лавлагаа /он харгалзахгүй/	1000
2	Даатгуулагч иргэд 1995 оноос хойш Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн цалингийн лавлагаа /он харгалзахгүй/	1000
3	Тендерт оролцогч аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэлийн өр, авлагатай эсэх болон гадаадаас ажиллах хүч оруулж ирэх аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр даатгуулагчийн тоо, цалингийн сангийн талаар нэг удаа гаргасан лавлагаа	1000
4	Гадаад оронд зорчих виз гаргуулах аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагч, иргэдийн хүсэлтээр гаргасан лавлагаа /хүн тус бүрээс/	1000